Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь “Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ хийж, бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшигийн эрсдэлээс сэрэмжлүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Ус цаг уур орчны шинжилгээний үнэн зөв мэдээллээр хэрэглэгчдийг хангах,
- Байгаль, цаг агаарын болзошгүй аюул, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэрэмжлүүлэх,
- Цаг агаар, уур амьсгалын нөөцийг бүрэн дүүрэн ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэх,
- Ус цаг уур орчны төлөв байдлын урьдчилсан болон горимын үнэн зөв мэдээ, мэдээллээр төр засаг, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд шуурхай үйлчлэх,
- Нутаг дэвсгэртээ нислэг үйлдэж буй агаарын хөлгийн нислэгт цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээгээр үйлчилж нислэгийн аюулгүй байдлыг хангах,
- Байгаль цаг агаарын болзошгүй аюултай болон гамшигт үзэгдэл, орчны ноцтой бохирдлоос сэрэмжлүүлэх,
- Ус цаг уур орчны хяналт шинжилгээний өртөө, харуулуудыг арга зүйн удирдлагаар хангаж, тэдгээрийн тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, холбоо, мэдээлэл сүлжээний найдвартай ажиллагаа, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах,
- Шинжилгээний зориулалттай хэмжих хэрэгслийн хангалт, техник технологийн шинэчлэлтийг хэрэгжүүлэх, багаж төхөөрөмж материалын нэгдсэн судалгаа гаргах, ашиглалтад хяналт тавих,
- Шинжилгээ мэдээлэл үйлчилгээний ажлын чиглэлээр гарч буй дүрэм заавар, стандартыг мөрдөж хэрэгжүүлэх,
- Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг зохицуулах,
- Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах, ажилд нь сургаж дадлагажуулах, мэргэжлийг нь дээшлүүлэх.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлт тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дугаар сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ЦУОШГ-ын Захиргаа, аудитын хэлтсээс дотоод хяналт тавьдаг бөгөөд тайлант онд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ЦУОШГ-ын даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/163 дугаар тушаалаар Цаг уур, орчны шинжилгээний салбарын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталсан байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79,214.7 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	9,300.0	9,300.0
Бараа материал	80,300.9	114,349.2	34,048.2
Үндсэн хөрөнгө	790,755.2	826,621.6	35,866.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>871,056.1</b>	<b>950,270.8</b>	<b>79,214.7</b>
Өр төлбөр	-	9,300.0	9,300.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	871,056.1	940,970.8	69,914.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>871,056.1</b>	<b>950,270.8</b>	<b>79,214.7</b>

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данс байна.  
Үүнд:

- Авлага болон өр төлбөр дансны үлдэгдэл 9,300.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь урсгал засварын гэрээт ажлын үлдэгдлийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлснээс,
- Бараа материалын дансны үлдэгдэл 114,349.2 мянган төгрөг болж 34,048.2 мянган төгрөгөөр өссөн нь Ерөө сумын цаг уурын өртөөний барилгын засварын 21,700.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан боловч зарцуулаагүй болон ЦУОШГ-аас 13,786.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 826,621.6 мянган төгрөг болж 35,866.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 118,065.8 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг худалдан авч, ЦУОШГ-аас 34,653.8 мянган төгрөгийн компьютер, багаж хэрэгслийг үнэ төлбөргүйгээр хүлээн авснаас тус тус шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,570,765.8 мянган төгрөг, өөрийн орлогоос 1,000.0 мянган төгрөг буюу нийт **1,571,765.8** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 241,851.2 мянган төгрөгөөр бууруулж **1,329,914.6** мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 49,425.3 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 51,486.4 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 38,260.0 мянган төгрөгөөр,

- Эд хогшил, урсгал засварын зардлыг 41,195.2 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 25,539.8 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 19,419.8 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг нийт 740,340.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, **2,070,255.4** мянган төгрөг болгон төсвийн зохицуулалт болон тодотгол хийсэн байна. Үүнд:

- 7 дугаар сараас албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор цалин хөлс болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 511,754.2 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 12,431.6 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 23,185.8 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 144,449.7 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 6,539.8 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 37,215.3 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 1,164.4 мянган төгрөгөөр,
- Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 3,600.0 мянган төгрөгөөр гэх мэт.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,069,255.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны өөрийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,069,255.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны өөрийн орлого 1,165.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,069,953.4** мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 302.0 мянган төгрөгөөр хэмнэж, 165.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

					/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/	
1	Ус цаг уур, орчны шинжилгээ, Үндсэн үйл ажиллагааны зардал	1,988,777.6	1,988,480.7	296.8	99.9	
2	Ус цаг уур, орчны шинжилгээ, Холбооны суваг ашигласны хөлс	4,150.1	4,150.1	0.0	100.0	
3	Ус цаг уур, орчны шинжилгээ, Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	77,327.7	77,322.6	5.1	99.9	
	<b>Дүн</b>	<b>2,070,255.4</b>	<b>2,069,953.4</b>	<b>302.0</b>	<b>99.9</b>	

*Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.*

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130013404 тоот дансанд ЦУОШГ-аас 980.0 мянган төгрөг, Сангийн сайдын 2023 оны 224 дүгээр тушаалаар үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгосон 9,479.5 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас, нэмэгдүүлэх ажлын 30,000.0 мянган төгрөг, агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллого зохион байгуулах ажлын 4,505.2 мянган төгрөг, үндсэн санхүүжилтийн данснаас 9,300.0 мянган төгрөг зэрэг нийт 54,264.7 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэн, 44,964.7 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, 9,300.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлэн, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

*Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.*

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь дээд шатны төсвийн захирагчийн баталсан 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах 2 худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна. Үүнд:

- 25,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Компьютер, техник хэрэгсэл худалдан авах”,
- 31,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Ерөө сумын цаг уурын өртөөний барилгын засварын ажил”.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг харьцуулалтын болон нээлттэй тендерийн аргаар сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажилласан байна. Үүнд:

- “Компьютер, техник хэрэгсэл худалдан авах” харьцуулалтын аргын сонгон шалгаруулалтад 6 байгууллага санал ирүүлснээс 19,965.0 мянган төгрөгийн буюу хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Голденхоул” ХХК гүйцэтгэгчээр шалгарсан байна.
- “Ерөө сумын цаг уурын өртөөний барилгын засварын ажил”-ын нээлттэй тендерт “Хүрэлсоёмбо” ХХК нь 29,867.1 мянган төгрөгийн үнийн санал ирүүлж, шалгарсан бөгөөд худалдан авах ажиллагааг оройтуулснаас шалтгаалан уг ажил 2024 оноос хэрэгжихээр гэрээ хийгдсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн үндсэн хөрөнгөтэй холбоотой 1 зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 07/26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,400,725.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 14,007.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны төсөв материаллаг хэмжээгээр өөрчлөгдсөн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 2,106,112.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон **21,061.1** мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тус төв нь БОАЖС-аас орон нутагт болон Улаанбаатар хотод албан томилолтоор ажиллахдаа хамгийн бага зардалтай байх тээврийн хэрэгслээр

үйлчлүүлэх замаар холбогдох зардлыг хэмнэх, үрэлгэн байдлыг таслан зогсоож, сахилга баттай ажиллах талаар өгсөн чиглэл болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор өр авлага үүсгэхгүй байх арга хэмжээг авч, зарим шинжилгээ судалгааны хөтөлбөрт ажил болон шалган туслах, автомат багажийн тооллого зэрэг ажлуудыг хамтатган хийлгэж, шатахуун томилолтын зардлыг, дулааны тоолуур худалдан авч, суурилуулан халаалтын зардлыг тус тус хэмнэж, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн мэдээлбэл зохих 156 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, “*Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл*”-ийн 12 дугаар сарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар албан хаагчдын улирлын ажлын мөнгөн урамшууллын зардлыг төсөвт тусган батлуулж, олгож байх 1 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1		1		100
Нийт дүн	1		1		100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ерөө сумын цаг уурын өртөөний барилгын засварын ажил тайлант онд хийгдээгүй бөгөөд гэрээт ажлын хэрэгжилтийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй юм.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,937.9 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Нэмэлт төсвийн санхүүжилтийн орлогыг 9,300.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй мод, бут зэрэг хөрөнгийн ашиглах жилийг хасах дүнгээр илэрхийлж, үндсэн хөрөнгийн үлдэх өртгийг 637.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн зэрэг.

Аудитаар нийт 19,423.6 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 1,304.6 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 18,119.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, 1 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

5.1.1. Тус төвийн даргын 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн Б/46 дугаар тушаалаар цаг уурын өртөөний ажиглагч М.Энхманлайд 1 сарын цалинг 20.0 хувиар буюу **208.6** мянган төгрөгөөр бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан боловч суутгал хийгээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хүлээнэ. 20.2.5: “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ногдуулаагүй сахилгын шийтгэлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.1.2. Албан хаагчдыг аймаг, сумдад албан томилолтоор ажилласан хугацаанд хоолны хөнгөлөлтийн **1,096.0** мянган төгрөгийг давхардуулан тооцож, олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5: “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон хоолны хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

## **5.2 Албан шаардлага**

5.2.1. Ерөө сумын цаг уурын өртөөний барилгын урсгал засварын ажлыг тайлант хугацаанд гүйцэтгээгүйн улмаас гэрээний үлдэгдэл санхүүжилт болох **9,300.0** мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ.”, 45.2.2: “Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, ... бий болсон үлдэгдэл.” гэж заасныг болон 47 дугаар зүйлийн 47.1, 47.1.1-47.1.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлэх, нэмэлт санхүүжилтийн дансыг зориулалтын дагуу ашиглах албан шаардлага хүргүүлэх.

5.2.2. Жилийн эцэс буюу тайлант оны 11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр унаа, хоолны хөнгөлөлтийн батлагдсан төсөв хэмнэгдэхээр байтал хэмнэлтийг татан төвлөрүүлэхээс зайлсхийж, тус төвийн даргын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/71 дүгээр тушаалаар унаа, хоолны хөнгөлөлтийг 20.0-23.0 мянган төгрөг болгон тус тус нэмэгдүүлж, /2023 оны 07 дугаар сард 8-12.0 мянга, 11 дүгээр сард 10.0-16.0 мянган төгрөг болгон шинэчлэн тогтоосон/ нийт **8,819.0** мянган төгрөгийн нэмэлт зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.2-т “**Нийтийн тээврийн тогтмол үйлчилгээтэй** хот суурин газарт ажиллаж байгаа энэ журмын 8.1-д

зааснаас бусад төрийн албан хаагч нь ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зайлшгүй шаардлагатай бол нийтийн тээврийн унааны зардлын 50 хувийг байгууллагаас нь нөхөн олгоно”, 8.4 дэх “Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын **тодорхой хэсгийг** байгууллагаас нөхөн олгоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, жилийн эцэст төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэх.

### **5.3 Зөвлөмж**

#### **Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийг шинээр хүлээн авах болон холбогдох шийдвэрийг үндэслэн агуулахаас ашиглалтад өгөх буюу албан хаагч, сумдын цаг уурын өртөөдөд шилжүүлэхдээ “Үндсэн хөрөнгийг хүлээн авах, шилжүүлэх баримт”, “Үндсэн хөрөнгийн дотоодод шилжүүлэх дагалдах хуудас” зэрэг маягтуудыг үйлдээгүй, хүлээлгэн өгсөн, хүлээн авсан ажилтны гарын үсгээр баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар “Маягт, заавар батлах тухай” тушаал зэргийг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг хүлээн авах, дотооддоо шилжүүлэхдээ холбогдох маягтыг бүрэн, үнэн зөв хөтөлж, баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>3</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>3</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
							Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо
Нэмэлт төсвийн орлогыг дутуу тайлагнасан	1	9,300.0	1	9,300.0			1	9,300.0				
Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй мод, бутны ашиглах жилийг хасах дүнгээр илэрхийлсэн	1	637.9			1	637.9	1	637.9				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>9,937.9</b>	<b>1</b>	<b>9,300.0</b>	<b>1</b>	<b>637.9</b>	<b>2</b>	<b>9,937.9</b>				

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сахилгын шийтгэлийг ногдуулаагүй	1	208.6	1	208.6								
Хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон	1	1,096.0	1	1,096.0								
Төсвийн хэмнэлтийг төвлөрүүлэлгүйгээр зарцуулсан	1	8,819.0			1	8,819.0						
Хэрэгжээгүй гэрээний үлдэгдэл санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн	1	9,300.0			1	9,300.0						
Үндсэн хөрөнгийн анхан шатны маягтыг бүрэн хөтлөөгүй	1										1	
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>19,423.6</b>	<b>2</b>	<b>1,304.6</b>	<b>2</b>	<b>18,119.0</b>	<b>1</b>	<b>18,119.0</b>			<b>1</b>	

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээллийг хугацаа хоцроосон	1						1	
<b>Дүн</b>	<b>1</b>						<b>1</b>	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>						<b>1</b>	